



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.05.01 № А-1/1826
танай _____-ны № _____-т

**Тодруулгын хариу хүргүүлэх
тухай**

Тус газраас зарласан ЦХХХЯ/20240101003 дугаартай XXV.1.7 "Үүрэн холбооны сүлжээ сайжруулах станц /Хөвсгөл, Төмөрбулаг, Цагаан-үүр, Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх сум" УТ2406700145 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн дараах хариуг хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТШЗ 2.1 батлагдсан төсөвт өртгийн 2024 онд санхүүжих дүн 630,000,000.00 төгрөг гэж дурьдсан байна. Энэхүү санхүүжих дүн тендерийн аль байршлуудад хамаарч буй тухай тодруулга авах хүсэлтэй байна.	Төслийг нийт 7 багцад хуваасан бөгөөд багц тус бүрийн хувьд тухайн жилд санхүүжих дүн нь 90,000,000.0 (ерэн сая) төгрөг байна.
2	ТШЗ 19.1 ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардах: Шаардахгүй гэж дурьдсан байна. энэ нь ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж техник хэрэгслийн мэдээллийг тендерийн материалд тусгах шаардлагатай эсэх;	Тендерийн баримт бичгийн "ТШ (19.1)" хэсэгт ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Мэдээлэл ирүүлэх шаардлагагүй.
3	ТШЗ 19.2.6 Захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлуудыг өөрийн төсөвт тооцож ирүүлнэ гэж дурьдсан байна. Захиалагчийн хяналтын зардлыг тухайн байршил, цэг дэх нийт санхүүжилтийн дүнгийн хэдэн хувиар /эсхүл дүнгээр/ тооцох;	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 30 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын төсөв зохиох" дүрмийн дагуу тооцно.
4	БА-3.1 цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохилжилтын ажил, Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий туслан гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, туслан гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлүүдийг тендерийн баримт бичгийн бүрдэл болгон материалыг илгээхэд энэ нь тендерийн баримт бичгийн ТШЗ 19.3 шаардлагыг хангана гэж үзэх эсэх;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.4-т "Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно." Гэж заасан. Тендерт оролцогч нь тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд худалдан авах ажиллагааны цахим системд хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

ДАРГА

Ц.БАТЗУЛ

1324024903

*020020105 СБТ-11251 6529909